

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2024 оны 02 дугаар сарын 09

Дугаар 90

Улаанбаатар хот

Дүүргийн Улаан загалмайн хороонд
санхүүжилт олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.17 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Монголын Улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийг тус тус үндэслэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын арван зургадугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1.Баянзүрх дүүргийн Улаан загалмайн хороонд дэмжлэг үзүүлэх зорилгоор ажлын гүйцэтгэлд үндэслэн сар бүр 15 сая хүртэлх төгрөгийн санхүүжилтийг олгосугай.

2.Санхүүжилтийг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний зардлаас гаргахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга (Ч.Мэндсайхан), Ерөнхий нягтлан бодогч (Г.Төрхүү) нарт зөвшөөрсүгэй.

3.Баянзүрх дүүргийн Улаан загалмайн хорооны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг сар бүр дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албанд тайлагнаж ажиллахыг Улаан загалмайн хороон дарга (Д.Жазмаа)-д даалгасугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын алба (Ч.Мэндсайхан)-д даалгасугай.

ДАРГА

А.БАЯР